

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт



АРЬС СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан мэргэшил дээшлүүлэх сургалт болон гадаад оронд сургалтын эрх, зөвшөөрөлтэй байгууллагад 1 сараас дээш хугацаагаар мэргэшил дээшлүүлсэн байх /хамгийн багадаа 12 багц цаг биелүүлсэн байх/;
2. Арьс судлалын чиглэлээрх мэргэжил арга зүйн бодлогын баримт, бичиг боловсруулах ажлын хэсэгт дангаар болон багаар оролцсон эсвэл санал өгсөн байх -1;
3. Судалгаа шинжилгээний ажил: Илтгэл, өгүүлэл мэргэжлийн хурал зөвлөгөөн, сэтгүүлд – 5.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Арьс судлалын чиглэлээрх мэргэжил арга зүйн бодлогын баримт, бичиг боловсруулах ажлын хэсэгт дангаар болон багаар оролцсон байх /5-аас доошгүй удаа/;
2. Өөрийн байгууллагын залуу эмч, резидент эмч болон оюутан нарт багшилсан байх, иргэдэд өвчинөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах ухааны талаар сургалт зохион байгуулсан байх /хамгийн багадаа 12 цаг/ ;
3. Мэргэшлийн чиглэлээр зохион байгуулсан багц цагийн богино хугацааны сургалт удирдсан байх / 3- аас дээш удаа /;
4. Судалгаа шинжилгээний ажил: Илтгэл, өгүүлэл –дотоод -5, гадаад хурал, сэтгүүл-1.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Судалгаа шинжилгээний ажил: Ном товхимол бичсэн байх, илтгэл, өгүүлэл гадаадад -3;
2. Арьс судлалын чиглэлээр мэргэжил арга зүйн бодлогын баримт, бичиг боловсруулах батлуулахад 10 –аас дээш удаа оролцсон байх.